

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ХЭРГИЙГ БҮГД ЗАХИРАН ШИЙТГЭГЧ ЯАМ

1911-1921

MINISTRY OF ADMINISTRATION OF MILITARY AFFAIRS OF MONGOLIA



БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ХЭРГИЙГ БҮГД ЗАХИРАН ШИЙТГЭГЧ ЯАМ


THE MINISTRY OF MILITARY AFFAIRS OF THE BOGD KHANATE OF MONGOLIA

Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 буюу аргын 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Ylll Богд Живзундамба хутагтыг "Монгол Улсын эзэн, шашин төрийг хослон баригч, Наран гэрэлт Богд хаан"-аар өргөмжилж, 5 яам байгуулсны нэг нь Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам байв.

On December 29, 1911, the 9th day of the Midwinter of the Year of the White Pig, Ylll Bogd Jivzundamba was proclaimed the "Ruler of Mongolia, the Combine of Religion and the State, the Bright Bogd Khan," and five ministries were established, one of which was the Ministry of Military Affairs.

VIII Богд Живзундамба хутагт
1869-1924

VIII Bogd Jivzundamba Khutagt
1869-1924



Цэргийн яамны эрх хэмжээг тодорхойлсон Бүгд ерөнхийлөн захирах яамны бичиг. 1912 он.
An official letter from the Ministry of Military Affairs defining the authority of the Ministry of Military Affairs. 1912

МУУТА, ХА-3. Д-1. ХН-413. Б-4

Уг бичигт:

"... Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны эрхлэн шийтгэх хэргийг товчилбоос: Цэргийн засаг, чуулган чуулж, эр төөлөх, цэргийн түшмэлийг нөхөх, тавих хэргийг эрхэлж цэргийн үнэнийг хянан байцааж, улсын засагт туслан цэргийн түшмэл сонгон тавих өргөмжлөн, өглөгийн түшмэл өгөх жич, байлдах, дайдахад сургах, ухуулах, засаг цаазыг зарлах, дэлхий дахин газар орны зургийг эрхэлж, бэрх чухлыг мэдэн, гавьяаг ялган, эндэгдлийг байцаах, хөхиүлэх, залхаах, дэвшүүлэх, бууруулах, цэргийн данс, цэргийн эрдэмтнийг шалгах, цагдах, манах зэрэг хэргийг эрхлэн шийтгэнэ. Цэргийн тухайн чухал хэрэгт хурдан бичиг илгээх ба мэдээлэн түшмэлийг зарах зүйлд улаа шүүс хэрэглэх зэрэг хэргийг дангаар эрхэлж шийтгэнэ.

Басхүү цэргийн хүн аливаа гадаадын хүн лүгээ холбогдсон хэргийг Гадаад яам лугаа нийлэн байцааж шийтгэнэ. Жич, хянаваас аливаа улс төрд үйлдвэрээс эрхэм нь үгүй тул Цэргийн яамны дотроо үйлтгэх хэлтэс байгуулж, мөн үйлдвэрт хэрэглэх эдийн санг бэлтгэж, хааны үйлдвэр ба цэргийн зэвсгийг үйлдэж бэлтгэвээс зохино. Энэ үйлтгэх хэлтсийн эрхлэх хэргийн товч нь, дэлхий дахины урчууд үйлдвэрийг захирч хааны орд харш ба цэргийн гэр хороо, усны үйлдвэр, гүүр байгуулах, онгоц сал бэлтгэх цэргийн албаны аму тариа, түлш мод зэргийг бэлтгэх зэргийг эрхлэн шийтгэнэ. ..." гэж яамны эрх, хэмжээг тодорхойлсон байдаг.

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН ТӨРИЙН ДАЛБАА,ТАМГА
THE STATE BANNER AND SEALS OF PERIOD OF THE BOGD KHANATE OF MONGOLIA



Богд хаант Монгол Улсын төрийн далбаа

State Banner of the Bogd Khanate of Mongolia






Богд хааны Төрийн алтан тамга

State Golden Stamp of the Bogd Khan





Богд хааны Төрийн тамганы дардас бүхий бичиг

An official Letter sealed with the State Stamp of the Bogd Khan

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ХЭРГИЙГ БҮГД ЗАХИРАН ШИЙТГЭГЧ ЯАМНЫ ТЭРГҮҮН САЙДУУД


MINISTERS OF MILITARY AFFAIRS OF THE BOGD KHANATE OF MONGOLIA




Галсанцэвэгмэдийн Гомбосүрэн
1911-1914
Gombosuren Galsantsevegmed

VIII богд Жибзундамба хутагт Монгол Улсын Эрдэнийн сууринд залраад буулгасан хишиг тархаах Зарлигаас: "Үнэн санаагаар чармайн зүтгэсэн Сэцэн хан аймгийн хамаарсан жанжин засаг хошууны бэйс Гомбосүрэнд үе улиран Эрдэнэ Далай цол, төрийн жүн ван, улбар шар жолоо шагнаж, Шадар сайд, Бүгд захирах сайд, Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны тэргүүн сайд, туслагч жанжны тушаалд тохоон талбигтун" хэмээжээ.

Олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн дунд сарын шинийн есөн . 1911.12.29



МҮҮТА, ХА-6. Д-1. ХН-513. Б-3




Зарлиг: Дотоод яамны дэд сайд Доржпаламыг Цэргийн яамны тэргүүн сайдад тохоон тавигтун.

The decree, to appoint the Deputy Minister of Internal Affairs, Dorjpalam to the Principal Minister of Military Affairs of Mongolia

А-3, Д-1, ХН-530, Б-40





А-2, Д-1, ХН-266, Б-47

Зарлиг: Гуйсан ёсоор болгож, түүний оронд Бүгд ерөнхийлөн захирах сайд Намнансүрэнг хавсарган тохоон талбигтун.

The decree, to approve as requested and appoints the Prime Minister Namnansuren cooperatively to his position.


Төгс-Очирын Намнансүрэн
1915-1919
Namnansuren Tugs-Ochir



А-3, Д-1, ХН-1054, Б-46

Зарлиг: Ерөнхийлэн шийтгэх сайдын тушаалыг Бадамдоржид хавсруул.
Харьяат яамны сайдад Жамьяндоржийг тохоон талбигтун.
/Олноо өргөгдсөний есдүгээр он дөрвөн сарын хоёр/

Decree, to cooperate the position of the Minister to Batdorj and appoint Jamiyandorj to the position of Affiliate Ministry.
The proclaimed decree on appointing the Prime Minister and Principal Minister
/the 2nd of April, the year of 9 when the throne is proclaimed/



Богд хаант Монгол Улсын цэрэг
Уг зургийн эх Франц дахь Алберт Каны музей
Гэрэл зурагчин Стефан Пассе, 1912 он

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН ХЭРГИЙГ БҮГД ЗАХИРАН ШИЙТГЭГЧ ЯАМНЫ БҮТЭЦ

STRUCTURE OF THE MINISTRY OF MILITARY AFFAIRS OF THE BOGD KHANATE OF MONGOLIA

Богд Жавзандамба хаан

Ерөнхийлөн шийтгэх сайд

Харуул-Аж ахуй

Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам

Зэвсгийн газар

Цэргийн засгийг явуулах хэлтэс

Цэрэг тэгшлэх хэлтэс

Зэрэг дэвийг хянан байцаах хэлтэс

Богд хан хайрхан уулын чуулганы дарга, жанжин
Хан Хэнтий уулын чуулганы дарга, жанжин
Хантайшир уулын чуулганы дарга, жанжин
Цэцэрлэгийн чуулганы дарга, жанжин

ҮҮРЭГ НЬ

- Цэргийн засаг цаазыг тархаах, хамгаалах, тохинуулах ;
- Дайлаар мордуулах;
- Эр төөлөх;
- Дотоодыг хамгаалж сэргийлэх;
- Цэргийн зэвсгийг байцаах;
- Нөхөн хангах;
- Цэргийг сургаж боловсруулах, шалгах;
- Түшмэлийн зэрэг дэвийг хянан байцаах;
- Түшмэл, цэрэг, ардыг сайшаан шагнах;

Дөрвөдийн зүүн гарын Бат-ерөөлт Төгс хөлөг Далай ханы чуулганы дарга, жанжин
Дөрвөдийн баруун гарын Үнэн зоригт ханы чуулганы дарга, жанжин


Олон хошууны захирагч данги

Сумын данги, орлон хөөгч

Арван гэрийн дарга

БОГД ХААНТ МОНГОЛ УЛС, ХААНТ ОРОС УЛСЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ЦЭРГИЙГ БЭЛТГЭН СУРГАХ ТУХАЙ ГЭРЭЭ

TREATY ON TRAINING OF MILITARY TROOPS BETWEEN BOGD KHANATE OF MONGOLIA AND RUSSIAN EMPIRE




Төлөөлөгчид Нийслэл Хүрээнд 1912.11.03-ны өдөр гэрээг Монгол-Орос хэл дээр үйлдэн гарын үсэг зуржээ.

The delegates in Niislel Khuree (the old Ulaanbaatar) The treaty was signed in both Russian and Mongolian on November 3, 1912.



Сайн ноён хан Т.Намнансүрэн, И.Я.Коростовец тэргүүтэй Монгол-Оросын төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурсны дараа. Нийслэл Хүрээ. 1912 он

Sain Noyon Khan T.Namnansuren and Mongolian and Russian delegates led by E.Ya.Korostovecy after signing the treaty, Niislel Khuree, 1912



Хаант Орос Улсаас цэргийн дарга, түшмэдийг урин авчирч Монгол цэрэгт цэргийн эрдэм заалган боловсруулах тухай Монгол, Орос гэрээ бичиг. 1913.02.16.

The Mongolian and Russian Agreement on inviting commanders and officials from the Russian Empire for military training of Mongolian military personnel, 16 Feb 1913



Хужирт булан дахь Цэргийн сургуулийн бага дарга нар орос сургагчийн хамт.
Junior officers of military school with Russian instructors in Khujirt bulan.

Бичгийн хөрвүүлэг:

Их орос улсын Хаан эзний хэргийг шийтгэх газраас тусгайлан гаргасан действительни са со Иван Коростовец Монгол Улсын Хаан эзний Засгийн газраас тусгайлан гаргасан шадар сайд, Дотоод зэрэг олон яамны хэргийг бүгд ерөнхийлөн захирах сайд, Түмэнхэн Номун эзэн, Сайн ноён хан Намнансүрэн, Шадар сайд, Бүгд захирах сайд, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайд, Засаг төрийн Эрдэнэ далай жүн ван Гомбосүрэн нар зөвлөн хэлэлцэж, монголын цэрэг бэлтгэн сургах гэрээ бичиг байгуулж жагсаан бичсэн.

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ "ЭРДЭНИЙН ОЧИР" ОДОН
"ERDENIIN OCHIR" - THE HIGHEST STATE AWARD OF THE BOGD KHANATE OF MONGOLIA



Тэргүүн зэргийн "Эрдэнийн Очир" одон
The First Grade "Erdenin ochir"



Дэд зэргийн "Эрдэнийн Очир" одон
The Second Grade "Erdenin ochir"





Гутгаар зэргийн "Эрдэнийн Очир" одон
The Third Grade "Erdenin ochir"

Хаант Монгол Улсын цэргийг сургах хэрэгт үнэн санаагаар хичээнгүйлэн зүтгэсэн орос цэргийн сургагч хурандаа Надежный-д бэйлийн зэрэг, Эрдэнийн очир одон, дэд хурандаа Брауншвейгт бэйсийн зэрэг, Эрдэнийн очир одон, Ротмистр Михайлов, Панаев нарт улсын түшээ гүнгийн зэрэг, Эрдэнийн очир одон, штабс-ротмистр Пото, Роговский, Слевицкий, подесаул Войлошников, Кайзер нарт туслагч гүнгийн зэрэг, Эрдэнийн очир одон, ... Орос нутагт буй Элчин сайд Коростовецийн хөвгүүн коронят зэргийн Коростовец, Эрхүү хотын генерал губернатор сайдын хөвгүүн поручик зэрэг Киняев /Князев/ нарт улсад туслагч гүнгийн зэрэг, Эрдэнийн очир одонг Богд эзэн хааны зарлигаар тус тус хүртээж, гавьяаг нь үнэлжээ.



нгол Улсын цэргийн жагсаал Mongolian Military parade

Монгол улсад 15 мянган "берданок" өгсөн тухай Эрхүүгийн цэргийн тойргийн ерөнхий командлагч В.Н.Никитин Жанжин штабын дарга В.А.Сухомлиновд бичсэн тайлан/рапорт

Эрхүү хот 1912 оны 2 сарын 17/3
сарын 01/

НУУЦ

Өнгөрсөн оны 11 сарын 4 өдөр №2173 телегармм-аар эрхэм та Монгол улсад 15 мянган берданок олгох тогтоолыг надад хариуцуулан өгсөн.

Иймд миний бие дараах илгээх тушаалыг тавьсан:

1. Усть-Кяхтад
   1911 оны 11 сарын 5 – миний хариуцлагийн бүсэд байсан 2050 ширхэг,
   1911 оны 12 сарын 17 – Заамурскын тойргоос илгээсэн 2500 ширхэг,
   1912 оны 11 сарын 26 – 3552 мөн 2 сарын 7 – Заамурскын тойргоос 3603,
   Приамурскын цэргийн тойргоос 1030 ширхэг.
   Нийт – 12735 ширхэг.
2. Акшуд
   1911 оны 11 сарын 5 – Заамурскын тойргоос 1000 ширхэг.

Монголчуудад зэвсэг олгох ерөнхий гарын авлага надаар итгэмжлэгдэж, Эрхүүгийн амбан захирагч хурандаа Хитров-оор зөвшөөрөгдсөн болно.

Дээр тусгаснаас гадна Заамурскын тойргийн дарга, генерал Мартов, баргууд болон баруун монголчууд 1265 ширхэгийг өгсөн.

Үүгээр монголчуудыг зэвсгээр хангах ажиллагаа дуусгавар болсныг тайлагнаж байна.

Артиллерийн генерал В.Никитин
Штабын дарга, дэслэгч-генерал Марков



Хаант Орос Улстай байгуулсан гэрээний дагуу Монгол цэргийг зэвсэглэж байлаа.1912 он
The Mongolian troops were armed under the treaty with Russian Empire. 1912

ХОВД ХОТЫГ ЧӨЛӨӨЛӨХ 1912 ОНЫ БАЙЛДААНЫГ УДИРДСАН ЦЭРГИЙН ЖАНЖИД

MILITARY GENERALS LED THE BATTLE FOR LIBERATION OF KHOVD CITY IN 1912



Баруун хязгаарын илбэн тохинуулах сайд Жалханз хутагт С.Дамдинбазар

The Minister for pacification of the west border, Jalhants Khutagt S.Damdinbazar



Баруун хязгаарыг төвшитгөн тогтоох цэргийг дайчлах сайд Манлай баатар Жамсрангийн Дамдинсүрэн

The Minister for military conscription to maintain the west border, Manlaibaatar Jamsanagyn Damdinsuren



Баруун хязгаарыг төвшитгөн тогтоох цэргийг дайчлах сайд Хатанбаатар Сандагдоржийн Магсаржав

The Minister for military conscription to maintain the west border, Khatanbaatar Sandagdorjyn Magsarjav



Ховдыг чөлөөлсөн нь
Зураач О.Дарамбазар
Зотон, тос, 1995 он
Liberation of Khovd city.
O.Darambazar, canvas, 1995



Хатанбаатар Магсаржавын дээл
1911-1921 он, Торго
Khatanbaatar Magsarjav's deel
1911-1921
Silk



Цэргийн дун бүрээ
XIX-XX зуун, Яс
Military Trumpet made of a shell
XIX-XX centuries
Bone



Манлай баатар Дамдинсүрэнгийн бүс
1911-1921 он, шир, гууль, хаш чулуу
Manlaibaatar Damdinsuren's belt
1911-1921
Leather, brass, and jade



Сангийн хэрэм доторх Гэсэр сүм.1910 он
Ховд аймгийн орон нутаг судлалын музейн сан хөмрөгөөс

Geser Temple inside of the Sangiin Kherem (Treasury Wall)
From database of the Museum for Country Studies, Khovd province. 1910



Сангийн хэрэм. 2021 он
Sangiin Kherem. 2021

ХИЛ ХЯЗГААРАА ХАМГААЛЖ, ӨВӨР МОНГОЛЫГ ХЯТАДЫН ТҮРЭМГИЙЛЭГЧДЭЭС ЧӨЛӨӨЛӨХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛ

THE STRUGGLE FOR BOUNDARY DEFENSE AND LIBERATION OF INNER MONGOLIA FROM CHINESE INVADERS



А-2, Д-1, ХН-81, Б-6




Манлайбаатар, төрийн жүн ван Дамдинсүрэнгийн аян дайнд авч явж байсан туг
The flag carried by the jun van (statesman) Manlaibaatar, Damdinsuren during the battle.



Зүүн өмнө хязгаарыг захирсан жанжин Ж.Дамдинсүрэн бие хамгаалагчдын хамт

J.Damdinsuren, who ruled the east-south border, with his bodyguards



А-3, Д-1, ХН-495, Б-49

Шилийн голын чуулганы Зүүн Хуучид вангийн хошуунд хятад цэрэг үлэмжхэн цөмрөн ирж, байлдан бүхий учрыг айлтгасан айлтгал
A decree act that announced the invasion and the battle by Chinese troops at the Zuun Huuchid vangiin Hoshu (old administrative unit) of Shilin Gol

ЦЭРГИЙН ЯАМНЫ ШҮТЭЭН, ТУГ ДАЛБАА
IDOL AND FLAG OF THE MINISTRY OF MILITARY AFFAIRS



Монгол Улсын Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны шүтээн “Улаан жамсран” бурхан

Idol “Red Jamsran” of the Ministry of Military Affairs of Mongolia




Монгол Улсын Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч яамны туг
Монголын Үндэсний Музейн сан хөмрөгөөс

The Flag of the Ministry of Military Affairs of Mongolia



1919 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 5 яамны тамгыг хуурааснаар 1911-1919 оны үйл ажиллагаа явуулсан Богд Хаант Монгол Улсын Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам татан буугдсан.

On November 17, 1919, with the removal of the seals of five ministries, the Ministry of Military Affairs, which had been in charge of the Mongolian Military Affairs from 1911 to 1919, was disbanded.



МУУТА, ТБА, ХА-3, Д-1, ХН-1146, Б-18

1921 оны 2 дугаар сарын 10. Барон Унгерний тушаалаар хуучин Шүүх яамны байшинд ноёд түшмэд, ван гүн нарыг зарлан хуралдуулж, төр засгийн хэргийг хэлэлцүүлж, Автономит засгийг дахин байгуулж, Богдыг хаан ширээнд залах, Дотоодын зэрэг таван яамыг байгуулж, сайд түшмэдийг томилох асуудлыг хэлэлцжээ.

The officials (vans, guns) were called for a meeting under the order by Baron Ungern in the house of old Ministry of Justice. During the meeting, governmental issues were discussed, an Autonomic government was reformed, which discussed to crown the Bogd to the king, to establish five ministries, including internal affairs, and appointments of relevant ministries and officials. 10 February 1921.



Роман Федорович Унгерн фон Штернберг Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхаглах үйл явцад зохих нөлөө үзүүлсэн.

Roman Petedrovich von Ungern-Sternberg has made some contributions in the activity of Mongolia to proclaim the Independent of Mongolia.



Богд хааны зарлигаар
Цэргийн яамны тэргүүн сайдад
Бишрэлт ван Доржцэрэнг тохоон
томилсон.

Bishrelt van Dorjtseren was assigned to Principal Minister of Military Affairs in accordance with the decree of the Bogd Khan.



Богд хааны зарлигаар Эрдэнэ дайчин
жонон чин ван Цогбадрахыг Цэргийн
яамны сайдаар 1921 оны 05 дугаар
сард тохоон томилосон.

Erdene daichin Jonon van, Tsogbadrakh was assigned to Minister of Military Affairs in May 1921 in accordance with the decree of the Bogd Khan.



МУУТА, ТБА, А-3, Д-1, ХН-1145, Б-28

Цэргийн яамны тэргүүн сайдыг томилсон зарлиг.
The decree to appoint the Principal Minister of Military Affairs



Барон Унгерний дэд жанжин гүн Жигмэджавын Жамбалон. 1921 он
Baron Ungern’s Deputy general, Jambalon Jigmedjav